



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

᠑᠙᠑᠑ оны ᠐5 сарын 25 өдөр

Дугаар 4/᠑35

Мандалговь

Их Угтаал уулын тахилгад  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66.1, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 9 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн тахилгатай “Их Угтаалын уул”-ыг тахих уламжлалт ёс, зан үйлийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100384